

“Яамны дүрэм”-ийн тухай

3. Нинжбадгар

Товч агуулга: Монгол улсын Үндэсний Нийтийн Номын Сангийн гар бичмэлийн сан хомрогт хадгалагдаж буй Жавзандамба хутагтын шавийн захиргаа буюу Эрдэнэшанзудбын яамны гурван дүрмийн тухай танилцуулж, эхийг монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлэн, тайлбар хийв.

Түлхүүр үг: Эрдэнэшанзудбын яам, Яамны дүрэм, Халх журам

1. Удиртгал

Монголын хутагт хувилгаад тэдний шавь нарын түүхийг судлахад тэднийг захирах захиргаанд холбогдох түүхэн баримт мэдээ нэн чухал юм.

Хууль цааз, дүрэм, журам нь тухайн цаг үеийнхээ нийгэм, ахуй соёлын олон талт мэдээллийг агуулсан байдгаараа үнэ цэнэтэй бөгөөд түүхийг судлах, танин мэдэх чухал сурвалж хэрэглэгдэхүүн болдог. Тиймээс бид энэ удаа Жавзандамба хутагтын шавийн захиргаа (Монголын түүх бичлэгт Эрдэнэшанзудбын яам хэмээдэг)-нд баримталж байсан дүрмүүдийн тухай товч танилцуулахыг зорьлоо.

Дүрэм гэдгийг Монгол хэлний болон хууль зүйн тайлбар толиудад дараах байдлаар тайлбарлажээ. Үүнд:

- Нэгэн юмны хэм журмыг тогтоосон заавар, тогтоол, хэвшиж нэгэнт заншсан ёс журам¹
- Тогтсон хэмжээсийг дүрэм хэмээмүй. Бас хууль дүрэм хэмээн холбож хэлэлцмүй²
- Эрт эдүгээгийн эрхт товчоот газраас заан тогтоосон дэс дараа³
- Хууль, үлгэр, журам⁴
- Эрх зүйн төрөлжсөн актын нэгэн төрөл, тодорхой байгууллага эсвэл улсын юуны өмнө аж ахуйн үйл ажиллагааны аливаа нэгэн хүрээний эрх зүйн байдлыг зохицуулсан хэм хэжээний иж бүрдэл акт⁵

¹ Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966. т. 218

² Хорин нэгт тайлбар толь. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. 1979. т. 737

³ Хорин наймт тайлбар толь. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо. 1994. т. 1754

⁴ Ш.Чоймаа, М.Баярсайхан, Э.Мөнх-Учрал, С.Батхишиг. Монгол хэлний хэл зүйн толь бичиг. Тэргүүн боть УБ., 2005.т. 291

• Төр, түүний байгууллага, төрийн бус байгууллага болон өмч эзэмшигч гаргадаг журам горимын нийлбэр⁶ гэж тайлбарлажээ.

Ингэвэл дүрэм гэдэг нь аливаа нэгэн байгууллагаас гаргадаг, тухайн байгууллагын үйл ажиллагаанд мөрдлөг болохын тулд тогтоосон хэм хэмжээг хэлдэг байна.

Энд өгүүлэх дүрмүүдээс гадна Бадаргуулт төрийн оны үед холбогдох Хамба номун хан, Дэд хамба, Эрдэнэ шанзудба, Да лам нарын зохиож, Жавзандамба хутагтын лүндэнээр батлагдсан, Хүрээний цогчин, шавийн захиргаа зэрэг газруудад зориулсан дүрмүүд⁷ байх бөгөөд эл дүрмүүдээр мөн л дээрх газруудын дотоод үйл ажиллагааг зохицуулж байсан бололтой байдаг.

Ингэж Хамба номун хан, Дэд хамба, Эрдэнэ шанзудба, Да лам нар Хүрээний цогчин, шавийн захиргааны дотоод үйл ажиллагааг зохицуулах талаар дүрэм зохиож байсны шалтгаан нь Манжийн төрийн хууль, цаазуудад тэдгээр газруудын үйл ажиллагааны тухай зүйл заалт байдаггүйтэй холбоотой байж болох талтай.

Харин Жавзандамба хутагтын шавь дангаараа холбогдсон болон Халхын засаг хошууны харьяат нартай холбогдсон хүн амь, хулгай худал гэх мэт хэргүүдийг “Халх журам”, “Монгол цаазын бичиг”, “Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйлийн бичиг”, “Шүүх цаазын бичиг”, Урьд өмнө шийтгэж өнгөрүүлсэн хэргийн данс тухайлбал Улаан хацарт” зэргийг баримтлан шүүн шийтгэж байсан ажээ.

Хадгалагдаж буй байдал: Уг дүрмүүд нь Монгол улсын Үндэсний Нийтийн Номын Сангийн гар бичмэлийн сан хөмрөгт, 2899/96 шифр, бүдэг улаан өнгийн давууг цардан наасан хавтас, 25*25 сантиметр, улаан шугам бүхий давхарласан цаасан дээр 9-10 мөр, хар өнгийн бэхээр бичсэн, 35 хуудас, “Яамны дүрэм” нэртэйгээр хадгалагдаж байна. Зохиогдсон цаг хугацаа болон агуулгын хувьд ялгаатай гурван дүрмийг нэгэн дэвтэрт бичжээ. Иймээс бид уг дүрмүүдийг А, В, С хэмээн дугаарлая.

Судлагдсан байдал: Бидэнд мэдэгдээд байгаагаар эл дүрмүүдийг академич Ш.Нацагдорж, доктор С.Жалан-Аажав, доктор Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав нар зохиол бүтээлдээ дурдсан байна. Тухайлбал Ш.Нацагдорж абугай 1789 оны үесээр “Монгол шүүх цаазын бичиг” гэдэг манжийн хуулийг монгол даяар мөрдөх баримталж эхлэхийн хамт Халх журмыг зөвхөн Богдын шавийн дотор мөрдөх болсон гээд Яамны дүрэмд буй “.... Нэгэн зүйл. Яаманд шүүсэн хэргийн дотор аймаг хошуу хольцолдсон

⁵ С.Нарангэрэл. Эрх зүйн толь бичиг. УБ., 2008. т. 188

⁶ Хууль зүйн тайлбар толь. УБ., 2003. т. 101

⁷ МУУТА. М-85. Д-1. хн 1104

хэргийг цөм Монгол цаазын бичгийн ёсоор шийтгэмүй. Шавь дангаар холбогдсон хэргийг Өндөр гэгээний цагт зохиосон хуучин Халх журам бичгийн ёсоор шийтгэж дуусмуй” хэмээх хэсгийг иш татан шавь хошуу харилцан холбогдсон хэргийг Монгол цаазын бичиг, шавийн дотор гарсан хэргийг Халх журмын дагуу шийтгэж байсан⁸, “Яамны дүрэм” нь Эрдэнэ шанзудбын яамны эрх үүрэг, гүйцэтгэх ажлын хуваарийг тодорхойлон заасан дүрэм гэж үзжээ.⁹

Доктор С.Жалан-Аажав Монголын хууль цаазын дурсгал болох “Халх журам”-ыг судлахдаа “Яамны дүрэм”-ийг шинжилж Жавзандамба хутагтын шавьд Манжийн хууль цаазны нөлөө ямар нэгэн хэмжээгээр байсан¹⁰ гэж дүгнэсэн байна.

Эрдэмтэн судлаач Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав нар Яамны дүрэм нь шавь яамны доторх нийгмийн харилцааг зохицуулах эрх зүйн акт бөгөөд шавийн албан хэрэг хөтлөлт, аливаа шашны үйлийг эрхлэх, хэрэг зөрчлийг хянан шийдвэрлэх, шийдвэр биелүүлэх ажиллагаа зэрэг харилцааг зохицуулсан¹¹ төдийгүй “Яамны дүрэм”, “Улаан хацарт” нь хоорондоо хүйн холбоотой гэж үзсэн байна. Учир нь “Улаан хацарт”-ын зарим нэгэн агуулга, хэрэг шийтгэсэн байдлыг ажиглахад уг дүрмийг баримтлан аливаа асуудалд хандаж байсан бололтой¹² гэжээ.

2. Зохиогдсон он цагийн тухай:

“А” дүрэм нь Төр гэрэлтийн 5 (1825)-р онд 9 зүйлтэй, “В” дүрэм нь Төр гэрэлтийн хорьдугаар (1841)-р онд 43 зүйлтэй, “С” дүрэм нь Бадаргуулт төрийн 33 (1907)-р онд зохиосон байх бөгөөд зөвхөн ганц зүйлтэй.

“А” дүрмийн тухайд: Уг дүрэмд “Тамга яамны газар үүрд дагаж явах дүрэм хэмжээ тогтоон тушаах учир. Эдүгээ үзвээс даруй хариу явуулбаас зохих албаны хэргийн бичиг зүйлийг түшмэд дэмий өдөр саатуулсан нь буй. Олон газраас хүргэж ирсэн албаны бичгийг үзүүлэхэд бичээч нар дэмий өдөр удуулсан нь бас буй. Гагцхүү энэ төдийгүй зүйл зүйлийн осол цалгар гэм гарсан нь олон энэ цөм түшмэд бичээч нар найдалцахад хүрч бай саар үнэхээр албаны хэрэг шийтгэх ёс бус болмуй. Хэрвээ түшмэд бичээч нарыг даруй жасаа¹³ зохиож тулгаж шийтгүүлэхгүй болвоос нэн осолдох цалгардахад

⁸ Ш.Нацагдорж. Улаан хацарто. УБ., 1956. стр. 11

⁹ Ш.Нацагдорж. Манжийн эрхшээлд байсан үеийн Халхын түүх (1691-1911). УБ., 2008. т. 218

¹⁰ Халх журам. Хянан тохиолдуулсан С.Жалан-Аажав. УБ., 1995. т. 9

¹¹ Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав. Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн шинжилгээ (Улаан хацарт). УБ., 2010. т. 20

¹² Б.Баярсайхан, Б.Батбаяр, Б.Лхагважав. Монголын шүүн таслах ажиллагааны түүхэн сурвалж бичигт хийсэн шинжилгээ (Улаан хацарт). УБ., 2010. т. 21

¹³ Ээлж зохиож гэсэн утгатай ажээ.

хүрэхийн тулд шанзудба¹⁴, гүн¹⁵, да лам¹⁶ нар бид бүгдээр зөвлөж олон түшмэд бичээч нарыг жасаа зохиож өөр өөрийн шийтгэвээс зохих хэрэг зүйлийг сүүлд жагсаан бичиж тушаажухуй. Иймийн тул үүнээс хойш тамга яамны газар албаны хэргийн бичиг зүйлийг шийтгэхүүд эрхгүй энэ тогтоосон дүрэм хэмжээг дагаж шийтгэгтүн. Хэрвээ түшмэд¹⁷ бичээч нарыг даруй жасаа зохиож тулгаж шийтгүүлэхгүй болвоос нэн осолдох цалгардахад хүрэхийн тулд шанзудба, гүн, да лам нар бид бүгдээр зөвлөж олон түшмэд бичээч нарыг жасаа зохиож өөр өөрийн шийтгэвээс зохих хэрэг зүйлийг сүүлд жагсаан бичиж тушаажухуй...¹⁸ хэмээснээс үндэслэвэл Жавзандамба хутагтын шавийн захиргааг тэргүүлэгч Эрдэнэ шанзудба, Жавзандамба хутагтын сангийн хамаг

¹⁴ Жавзандамба хутагтын шавь нарыг захирах захирагч бөгөөд Өндөр гэгээн Занабазарыг 1649-1651 онд Түвэдэд залрахад Далай лам, Банчин-Эрдэнэ нараас түүнд 50 хэртэй түвэд шавь бараа болгон хайрласны дотор Барайбун жасын нярав шанзудба гэсэн хүн байсан мэдээ байх ба Өндөр гэгээнийг дагалдан Халхад ирсэн бололтой. Брайбун жасын нярав шанзудба үед ямар үйл ажил эрхэлж байсан талаарх мэдээ тодорхой бус юм. Манжийн Энх-Амгалангийн дунд үеэс (1690-ээд оны сүүлчээс) Өндөр гэгээний сан шавь нарыг захирагчийн үүргийг Эрдэнэ билэгт цолтой Дагвалхүндэв ламтан гүйцэтгэж байсан тухай мэдээ буй. 1709 онд Ивэн голын хөвөөнд "Турван хошууны их цааз буюу Халх журам"-ыг хэлэлцэн тогтоосон халхын зарим хошууны ноёдын чуулганд шанзудба Эрдэнэ билэгт оролцсон¹⁴ байх бөгөөд энэ үед шанзудбын эрхлэх ажил үүрэг, байр суурь нилээд тодорхой болжээ. 1723 онд Манжийн Найралт төв хаан Эрдэнэ шанзудбад "Шашныг мандуулагч Жавзандамба бламын хүрээний хэргийг ялган бүгд шавь нарыг захирагч Эрдэнэ шанзудбын тамга" хэмээх монгол, манж, түвэд үсэг бүхий тамга мөн сургах зарлиг олгожээ. 1723-1924 оны хооронд 21 шанзудба Жавзандамба хутагтын шавь нарыг захирах тамга барьжээ.

¹⁵ Тэнгэрийн тэтгэсний 30 (1765)-р онд Хамба номун хан Жамбалдорж, Эрдэнэ шанзудба байсан Сүндүвдорж, Эрдэнэ шанзудба Гомбодорж, хамба Шагдар нар Жавзандамба хутагтын сангаас дур мэдэн мөнгө авч удаа дараа Оросын зүг худалдаа хийсэн (1763 онд Манжийн төрөөс Оростой хийх худалдааг хаасан байв) хэмээн ГМТЗЯЯ-наас ял асуугдав. Иймээс Хүрээнд сууж хэрэг шийтгэж байсан харчины бэйс Хутуринга, амбан Фүнай нар Эрдэнэ шанзудбын тамгыг сайд (эл сайд бол шавийн захиргаанд байсан тушаал бөгөөд Да лам нарыг томилсноор энэ тушаал үгүй болсон бололтой байдаг) Динжин-Яримпилд орлуулан, гэсгүй Намжилсамбуу, гүнгийн зэрэг засаг Гэжайдорж нарыг гарган Хутагтын сангийн хэргийг шийтгүүлжээ. (МУУТА. М 1. Д-1. хн-231. т. 215-216, 247-249, 536-537, МУУТА. М-1. Д-3. хн-57. нугалбар-9) Ингэснээр Жавзандамба хутагтын шавийн захиргаанд хутагтын сангийн хамаг хэргийг байцаан захирагч хэмээх тушаалыг буй болов. 1911 оныг хүртэл эл тушаалд гүнгийн зэрэг засаг хүмүүс суусаар иржээ. Уг дүрмүүдэд гүн, засаг гэж гарч буй нь дээрх сангийн хамаг хэргийг байцаан захирагчийг хэлж байгаа хэрэг юм.

¹⁶ Улиастайд суух хязгаар дахиныг тогтоох зүүн этгээдийн туслагч жанжин Цэнгүнжавын (Тэрээр энэ үед Орос Манжийн хооронд Олхуны харуулын хэргээс үүдсэн маргааныг шийдвэрлэхийн тулд Тэнгэрийн тэтгэсэн хааны зарлигаар Хүрээнд ирж, хэрэг шийтгэж байжээ) "Хутагтын шавь нар урьдаас үлэмж өссөн, шанзудбад туслан хэрэг шийгэгч сайдууд дөч тавьд хүрсэн боловч шанзудбад жинхэнэ ёсоор тусалж чадахгүй байгаа нь III Жавзандамба хутагт нас багад тусгүй бөгөөд шанзудбад туслан хэрэг шийтгэх хоёр эсвэл дөрвөн да ламыг ор бий болгох" тухай айлтгаснаар Тэнгэрийн тэтгэсэн хаан 1767 оны 10 сарын 17-нд зарлиг гаргаж Эрдэнэ шанзудбад туслах Да ламын хоёр орыг бий болгожээ. Улмаар Эрдэнэ шанзудба нарын нэр цохсоноор сойвон Гончигчоймпил, гэхүй Намжилсамбуу нарыг Да ламын тушаалд томилов. (МУУТА. М-1. хн-2914. нугалбар-1, хн-2913. нугалбар-3)

¹⁷ Жавзандамба хутагтын шавийн захиргаанд алба хаших зайсанг мөн түшмэл хэмээн нэрлэх нь бий. Зайсан нь хар ба лам хэмээсэн ялгаатай байжээ.

¹⁸ Яамны дүрэм. т. 1а. МУУНС гар бичмэл хөмрөг.

хэргийг байцаан захирагч засаг гүн, да лам нар шавийн захиргаанд алба хаших зайсан түшмэд, бичээч нар ажил бие биедээ найдан, ажил албанд осол цалгар гаргах болсноос үүдэн тэдний өдөр тутам шийтгэх бичиг хэргийг үйлд мөрдлөг болгохын тулд эл дүрмийг зохиожээ.

“В” дүрмийн тухайд: Эл дүрмийн эхэнд “Эрдэнэ шанзудбын яамны газрын тогтмол албан ба их бага тушаалын зайсан түшмэд, бичээч, хиа нар хүртэл албаны хэргийг ёслох, таслах, явах зорчих, данслах үйлдэх зэрэг элдэв хэргийг хуучин журмыг мөрдөж зүйл дараалан анги ангиар жагсаан бичиж өргөх нь”¹⁹ хэмээснийг үзвэл шавийн захиргааны зайсан түшмэд, бичээч, хиа нарын шинэлэх цагаалах ёс болон өдөр тутам гүйцэтгэж байсан хүн амь, хулгай, худлын зэрэг элдэв хүнд хөнгөн хэргийг шүүн таслах, тус газрын үйл ажилтай холбоотойгоор гадагш явах, зорчих, шийтгэж дууссан, дуусаагүй хэргийг данслах зэрэг тус газарт эртнээс хийж ирсэн ажил үүргийг зүйл дараалан жагсаан, шавийн захиргааны тушаалтнуудад тус болох үүднээс бичсэн байна.

“С” дүрмийн тухайд: Хэн, ямар учир шалтгааны улмаас зохиосон болохыг бичсэнгүй. Энэ зүйлтэй ижил агуулга бүхий заалт МУУТА-т хадгалагдаж буй Бадаргуулт төрийн 24 (1898)-р оноос 33 (1907)-р оны хооронд Хамба номун хан, дэд хамба, Эрдэнэ шанзудба, да лам нарын зохиож, YIII Жавзандамба хутагтад лүндэнгээр батлуулахаар өргөсөн Хүрээний Цогчин, шавийн захиргаанд албан хаших тушаалтнууд болон шашин, ном, сургуулийн үйлд зориулан гаргасан дүрэм хэмжээнүүдэд²⁰ байгааг үзвэл Хамба номун хан, дэд хамба, Эрдэнэ шанзудба, да лам нар Жавзандамба хутагтын ордон, шавийн захиргааны болон Хүрээний сүм хийдийн тушаалтнуудын хариуцлагыг чангатгах үүднээс гаргажээ. Мөн эл зүйлийг 1821-1913 оны хооронд зөвхөн Жавзандамба хутагтын шавь нарын хооронд гарсан зарим хэргүүдийг шүүн тасалсныг бичсэн “Улаан хацарт”²¹ -д тэмдэглэсэн буй.

3. Агуулгын тухай

“А” дүрэмд зайсан түшмэд, бичээч нарын ажлын хариуцлагыг сайжруулж, тэд шавийн захиргааны бичиг хэргийн зүйлийг хэрхэн гүйцэтгэх тухай хуваарийг тусгажээ. Тухайлбал, “Яаманд зайсан түшмэд хуучин ёсоор өдөр бүр бүгдээр цуглаж хэрэг зөвлөлдөн шийтгэхээс гадна цаг бүр хоёр лам зайсанг нэр заан гаргаж яамны бичээч нэгийг авч албаны хэрэг зүйлийг дааж шийтгэгтүн. Цаг дараалан улируулан тушааж хүлээн авагтун”, “Саатуулж

¹⁹ Яамны дүрэм. т. 7. МУУНС гар бичмэл хөмрөг.

²⁰ МУУТА. М-85. Д-1. хн 1104

²¹ Улаан хацартаас хуулсан дүрэм. МУУНС гар бичмэл хөмрөг.

хождуулахад хүргэвээс тэр хоёр лам зайсан, нэг бичээчид асуугтун.²² Олон газраас хүргэж ирсэн албаны бичгийг шанзудбад үзүүлэхэд мөн өдөр тамгын бичээчээс үзүүлэгтүн. Гүн, да лам нарт үзүүлэхэд хэвээр хар түшмэдээс явагтун”²³ хэмээсэн байна.

“В” дүрэм нь нийт 43 зүйлээс бүрдсэн бөгөөд шавийн захиргааны үйл ажлын цар хүрээг илэрхийлсэн. Иймээс агуулгыг нь ерөнхийд нь дараах байдлаар авч үзвэл:

- Шавийн захиргааны орон тоо бүрэлдэхүүн, тэдний харьяалагдах байдал
- Тус газрын их бага тушаалтнуудын шинэлэх цагаалах ёс
- Жавзандамба хутагтад халхын дөрвөн аймаг, шавь нараас өргөх даншог наадам, цам бүжиглэх, Майдар бурхан эргэх зэргийг зохион байгуулах
- Манжийн хаанд Жавзандамба хутагтын барих есөн цагаан болон бусад бэлэг сэлтийг хүргэх үйлийг зохицуулах
- Жавзандамба хутагт гадагш морилох болон олонд мөргөл хайрлахад зайсан түшмэд бараа болох
- Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдын газрын хэрэглэл, өртөө улааг бэлтгэх
- Элдэв хэрэгт холбогдогсдыг шүүн шийтгэх, баримтлах дүрэм, журам хууль цааз гэх мэт шавийн захиргааны ажил үүргийн олон талыг тусгажээ.

“С” дүрэм нь “Аливаа тушаалын хүн албаны чөлөө аваад уг тогтоосон хугацааны гадна нэгэн өдрөөс дээш таван өдөрт гүйцвээс гурван мал, таван өдрөөс дээш арван өдөрт гүйцвээс таван мал, арван өдрөөс дээш хорин өдөрт гүйцвээс нэг есөн мал, хорин өдрөөс дээш гучин өдөрт гүйцвээс хоёр есөн мал, гучин өдрөөс дээш дөчин өдөрт гүйцвээс гурван есөн мал торсугай. Дөчин өдрөөс дээш болвоос чангалан нарийвчлан тодорхойлж хүндэд цээрлэл үзүүлэн залхаан шийтгэсүгэй. Гагцхүү уг чөлөө олгосон тэмдэг бичгийг албаны газраа авчирч тушаасан өдрөөс баримталж хэлэлцмүй” хэмээсэн нэгэн зүйлээс бүтэж байгаа бөгөөд тус захиргаанд алба хаших тушаалтан албанаас чөлөө аван чөлөөний хугацаа хэтэрсэн тохиолдолд оноох шийтгэлийн тухай тодорхойлсон буй.

Бид цаашдын судалгаанд зориулан “Яамны дүрэм”-ийг монгол бичгээс кирилл бичигт хөрвүүлэн, тайлбартайгаар танилцуулж байна.

²² Яамны дүрэм. т. 2-2а. МУУНС гар бичмэл хөмрөг.

²³ Яамны дүрэм. т. 3. МУУНС гар бичмэл хөмрөг.

Яамны дүрэм

Тамга яамны газар үүрд дагаж явах дүрэм хэмжээ тогтоон тушаах учир. Эдүгээ үзвээс даруй хариу явуулбаас зохих албаны хэргийн бичиг зүйлийг түшмэд дэмий өдөр саатуулсан нь буй. Олон газраас хүргэж ирсэн албаны бичгийг үзүүлэхэд бичээч нар дэмий өдөр удуулсан нь бас буй. Гагцхүү энэ төдийгүй зүйл зүйлийн осол цалгар гэм гарсан нь олон энэ цөм түшмэд бичээч нар найдалцахад хүрч бай байсаар үнэхээр албаны хэрэг шийтгэх ёс бус болмуй. Хэрвээ түшмэд бичээч нарыг даруй жасаа зохиож тулгаж шийтгүүлэхгүй болвоос нэн осолдох цалгардахад хүрэхийн тулд шанзудба, гүн, да лам нар бид бүгдээр зөвлөж олон түшмэд бичээч нарыг жасаа зохиож өөр өөрийн шийтгэвээс зохих хэрэг зүйлийг сүүлд жагсаан бичиж тушаажээ. Иймийн тул үүнээс хойш тамга яамны газар албаны хэргийн бичиг зүйлийг шийтгэхэд эрхгүй энэ тогтоосон дүрэм хэмжээг дагаж шийтгэгтүн. Хэрвээ урьд адил албаны хэргийг хэрэг болгохгүй саатуулж хожидуулах зэрэг учир буй аваас эрхбиш харьяат жасаа оносон түшмэд бичээч нарыг хамтаар байцаан шийтгэгтүн. Сайхан хичээгтүн. Үүний тул тушаав.

Төр гэрэлтийн тавдугаар он²⁴ цагаан сарын шинийн дөрөвнөө

Нэгэн зүйл

Яаманд зайсан түшмэд хуучин ёсоор өдөр бүр бүгдээр цуглаж хэрэг зөвлөлдөн шийтгэхээс гадна цаг бүр хоёр лам зайсанг нэр заан гаргаж яамны бичээч нэгийг авч албаны бичгийн хэрэг зүйлийг дааж шийтгэгтүн. Цаг дараалан улируулан тушааж хүлээн авагтун. Саатуулж хожидуулахад хүргэвээс тэр хоёр лам зайсан, нэг бичээчид асуугтун. Аливаа зайсан түшмэд, тамгын бичээч²⁵, яамны бичээч нар тус тусын оногдсон элдэв хэрэг зүйлийг цөм хуучин хэвээр шийтгэхээс гадна бичиг хуулга урьдаас нэн үлэмж болсон тул цаг бүр таваад сул бичээчийг нэмж жасаалан суулгаж туслуулагтун үүний гурав нь тамгын газар, хоёр нь яамны газар суумуй.

Нэгэн зүйл

Олон газраас хүргэж ирсэн албаны бичгийг шанзудбад үзүүлэхүйд мөн өдөр тамгын бичээчээс үзүүлэгтүн. Гүн, да лам нарт үзүүлэхүйд хэвээр хар түшмэдээс явагтун.

²⁴ Энэ нь нийтийн тооллын 1825 он ажээ.

²⁵ Жавзандамба хутагтын шавийн захиргаанд тамгын, яамны, сул бичээч гэсэн гурван төрлийн бичээч байсан ажээ. Дээрх дүрмээс үзвэл тамгын бичээч нь олон газраас ирсэн бичгийг Эрдэнэ шанзудбад айлтгах, мөн явуулах бичгийн эх зохиох, зохиолгох, тэрхүү бичиг бэлэн болох цагт Эрдэнэ шанзудбад үзүүлж, тамга даруулах зэрэг ажлыг эрхэлдэг байсан бололтой.

Нэгэн зүйл

Олон газраас хүргэж ирсэн албаны бичгийг анхан яамны түшмэд хүлээн авсаар даруй тамгын бичээч нарт хүргэсэн хойно бичиг үзүүлж, тамгын бичээч мөн даруй шанзудбад үзүүлэгтүн. Хэрвээ даруй завдахгүй учир буй аваас аль газраас ямар хэргийн учир хэдэн зүйл бичиг ирсэн явдлыг нэгэнтэйгүүр мөн өдөр шанзудбад ам сонсгон хэлэгтүн нэгэнтэйгүүр яаманд гаргаж гүн, да лам нарт үзүүлсэн хойно жич шанзудбад нөхөж үзүүлэгтүн. Гүн, да ламд үзүүлэх албаны бичгийг ирсэн өдрийг тооцож бүгд хоёр өдрийг бүү өнгөрүүлэгтүн. Хэрвээ эрхэм яаралтай хэрэг болвоос цаг даруй гүйцэтгэн үзүүлэгтүн. Хоёр өдөр хэмээхийг битгий баримтлагтун.

Нэгэн зүйл

Олон газраас хүргэж ирсэн албаны бичгийг шанзудба, гүн, да лам нарт үзүүлсэн хойно яамны бичгийн хэргийг дааж шийтгэх сарын хоёр зайсан, нэг бичээч хянан үзэж товч түүж дансанд тэмдэг авагтун. Үүнд гагцхүү гэдрэг хариу явуулах төдий хэрэг болвоос ирсэн өдрийг тооцож бүгд таван өдрийг өнгөрүүлэхгүй мөн сарын хоёр зайсangaас шанзудба, гүн, да лам нарт мэдүүлэн тамгын бичээч нарт тушааж эх шийтгэгч шанзудба, гүн, да лам нарт үзүүлж хурдан явуулагтун. Хэрвээ данс байцаах, зарлан байцаах, өчиг авах²⁶ зүйлийг завдаж сая гэдрэг явуулах хэрэг болвоос жич шаардан гүйцэлдүүлсэн цагт мөн энэ ёсоор хурдан шийтгэж явуулагтун.

Нэгэн зүйл

Яамны хамаг зарга заальхайн хэрэг, нийлэлтийн хэрэг зүйлийг хэвээр лам хар түшмэд дааж шийтгээд нийлэлтийн хэрэгт зарлах ардыг ер дутуу саатахгүй боллогтун. Бичгийн хэргийг цаг бүр хоёр зайсанд тулгаж шийтгүүлсэн гэвч хар түшмэд мөн хавсарч шийтгэгтүн. Шавь зуурын цагаан бичгийн хэрэг болвоос лам хар түшмэд нийгэмчлэн дааж шийтгэгтүн.

Нэгэн зүйл

Цаг бүр таваад сул бичээчийг нэмж жасаалан суулгасны тулд данс хуулганы зүйлийг сар сард бичиж төгсгөгтүн. Дэмий битгий улираагтун.

²⁶ Хэрэгтэнээс байцаалт авах

Нэгэн зүйл

Тамгын бичээч нар аливаа явуулах бичгийг түшмэдийн тушаасан өдрөөс эхэлж найман өдрийн дотор эх бичиг зохиох, үзүүлэх, бичих, тамга дарах зүйлийг завдаж гаргагтун. Маш будлиантай, маш хянах болвоос арван өдрийг өнгөрүүлэхгүй гүйцэтгэн шийтгэж гаргагтун. Эрхэм яаралтай хэрэг болвоос цаг даруй шийтгэж явуулагтун.

Нэгэн зүйл

Яаманд нийлж шүүсэн хэргүүдийн өчиг авах, эх салгахад сар бүр яамны бичээч нэгийг нэр заан гаргагтун түшмэд тушаасан өдрөөс эхэлж өчиг авах эх салгах хэргийг таван өдрийг бүү өнгөрүүлэгтүн. Гагцхүү шавь зуурын хэргийн өчиг авах шийтгэл гэх зэргийн хэрэг болвоос хэвээр яамны бичээч нар нийгэмчлэн хийж мөн энэ ёсоор дуусгагтун. Дэмий саатуулахгүй болгогтун.

Нэгэн зүйл

Тамга яамны бичээч нар аливаа зохиосон эх авсан өчиг зүйлийг даруй хуучин бичиг өчигт боловсорсон зайсан бичээч нарт үзүүлж засамжлуулагтун. Журганд²⁷ мэдүүлэх эх болвоос бүгдээр зөвлөж маш хянаж зохиогтун. Дэмий харилцан итгэж түлхэж битгий хайш яаш өнгөрүүлэгтүн. Тус тус маш санаа гүйцэтгэн шийтгэгтүн.

Төр гэрэлтийн хорьдугаар он²⁸ хаврын сүүл сарын аравны дэлгэрсэн сайн өдөр.

Эрдэнэ шанзудбын яамны газрын тогтмол албан ба их бага тушаалын зайсан түшмэд, бичээч, хиа²⁹ нар хүртэл албаны хэргийг ёслох таслах явах зорчих данслах үйлдэх зэрэг элдэв хэргийг хуучин журмыг мөрдөж зүйл дараалан анги ангиар жагсаан бичиж өргөх нь.

Нэгэн зүйл

Цагаан сарын шинийн нэгний их баяр билгийн эрхэм сайн өдрөө Яамны зайсан түшмэд бүгдээр яамлах хувцас өмсөж думдад ордноо бараалхаж Гэгээнэ³⁰ мөргөсөн хойно, мөн өдөр Эрдэнэ шанзудба ноён засаг, да лам нар бүгдээр яаманд морилж ёсчлон мөргөх хурим хуримлаад дараагаар

²⁷ Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яам

²⁸ Энэ нийтийн тооллын 1840 он юм.

²⁹ Ноёд, хутагт хувилгаадыг дагалдан үйлчилж явах доод тушаалтан. Жавзандамба хутагтын шавийн захиргаанд хиа хэмээх тушаал байсан ажээ.

³⁰ Халхын Жавзандамба хутагтын хэлж буй.

зайсан лам нарыг авч Дээрхийн³¹ амгаланг айлтгахад бараалхан суумуй. Бас дараагаар яаманд бараалхаж Эрдэнэ шанзудба ноёнтоны мэндийн мэдүүлдэг болгоо.

Нэгэн зүйл

Мөн сарын арван гурванд сангаас олон оронд өргөх тахилд яамны зайсан лам гурав хамт хэсэж мөргөхөөс гадна энэ өдөр Хүүхэн ноёны хурим хиймүй. Мөн арван дөрвөнд Хамба номун хан блам³², Эрдэнэ шанзудба ноён, засаг, да лам нар эхлэн зайсан түшмэд бүгдээр орнуудад хэсэж мөргөөд мөн хамт яаманд бараалхан ёслол мөргөмүй.

Нэгэн зүйл

Дээрхийн гэгээнтэн³³ аливаа газар залрахад алтан тамгат³⁴ (тамганд?) зайсан лам нэг, Дээрхийн гэгээнтэнээ зайсан нэг, хар зайсан хөлөгч хошоод, жич хиа нар бараа болохоос гадна Хамба номун хан бламтанд зайсан лам нэг, Эрдэнэ шанзудба ноётонд зайсан лам нэг, амбасад зайсан лам нэг бараа болмуй. Бусад бараа болсон хувилгаад лам нарт бага хиа нар нижгээд дагамуй. Жич явах яамны элдэв албаны хэргийг мөн эдгээр зайсан түшмэд хэлэлцэн мэдүүлж шийгэхээс өөр мөн эндээс ихээхэн албаны хэрэг ба Лүндэнээр³⁵ зарж орон хийдэд өргөл манз тавих амбас ихэсийн амар эрэх зэрэг хэрэгт зайсан ламыг явуулжухуй.

³¹ Жавзандамба хутагт юм.

³² Жавзандамба хутагтын гүрэм хийгээд хуврагийн хэрэгт тэргүүлэгч Хамба номун ханыг хэлж байна. Өндөр гэгээн Занабазарыг 1649-1651 онд Түвэдэд залрахад Далай лам, Банчин-Эрдэнэ нараас түүнд 50 хэртэй түвэд шавь бараа болгон хайрласны дотор хурлын ламд Намжил данцангийн ловон байсан мэдээ байх³² ба тэрээр Өндөр гэгээнийг дагалдан Халхад ирсэн бололтой. Лхас хийдийн Намжил данцангийн ловон лам Лувсанжамбалданзан Өндөр гэгээн Занабазарын шинэ байгуулсан сүм хийдүүдийн хурал номын төрөл зүйл, дэг жаягийг зохион тогтоож, лам банди нар бурханы ном зааж, анхны сахил санваартан нарыг буй болгох зэрэг олон үйлийг хийсэн учир "Хамба номун хан"-ны тушаалыг хүртсэн. Үүнээс хойш хамба номун ханы тушаалд Балжорравдан, Лувсанданзанжанцан (Ламын гэгээн буюу Эрдэнэ бандида хутагт 3.Н), Гэлэргравдандорж нарын олон лам хуврагууд суужээ. 1723 онд Манжийн Найралт төв хаанаас Хамба номун ханд "Шашныг мандуулах Жавзандамба бламын гүрэм хийгээд хуврагийн хэрэгт тэргүүлэгч Хамба номун ханы тамга" хэмээх үсэгтэй тамга, сургах зарлиг олгожээ.

³³ Халхын Жавзандамба хутагтыг хэлж байна.

³⁴ 1723 онд Манжийн хаан Халхын анхдугаар Жавзандамба хутагтад "Шашныг мандуулах" цол, алтан тамга, алтан навчит өргөмжлөл хүртээсэн. Энэхүү алтан тамгыг хэлж буй бололтой.

³⁵ Жавзандамба хутагтын эш, зарлиг.

Нэгэн зүйл

Дөрвөн аймгийн шавийн даншог³⁶ наадам бэлэглэхэд бөхийн оноот хар зайсан хошоод, бай хуримын мал юманд хар зайсан нижгээд, харваанд хар түшмэл нижгээд, бөхийн хөл харахад хар түшмэл нижгээд, ноён блам нарын цай бариулахад хар түшмэл хошоод³⁷, их бага хиа нар цөмөөр албан явмуй. Бас уралдах морин тавихад зайсан лам нэг, морь уралдах газар үзэх ба морины байн юм хуваахад зайсан лам нэг, амбаст³⁸ хурим хүргэхэд зайсан лам нэг явжухуй.

Нэгэн зүйл

Халхын ноёд, блам нар ихээхэн хэрэг тохиолдож Дээрхийн лүндэнээр бурхан адис сахиус ба, буян бэлэг захиа сэлтийг гадагш хүргүүлэх хэрэгт зайсан ламыг Халхын дөрвөн аймаг шавийн нийгэм өртөө улаагаар мордуулмуй. Жич Хамба номун хан, Эрдэнэ шанзудбын газраас зарах элч нарыг цөм шавийн төдий улаа хэрэглэмуй.

Нэгэн зүйл

Жил бүрийн намар цагт Дээрхийн газраас Эзнээ³⁹ барих есөн цагаан ба, бурхан морьдыг⁴⁰ зайсан лам нэг, бас Хамба номун хан, Эрдэнэ шанзудба ноёнтонгоос барих морьдыг⁴¹ хаалгач⁴² хоёрын хамт өөр өөрийн хүчээр хүргэж барихаас гадна басхүү санд хэрэглэх жимс зэрэг элдэв юмыг иргэдээс⁴³ худалдан авч шавиас гаргаж аваачсан тэмээдэд ачиж ирэх замд дөрвөн аймаг шавиас нийгэм улаагаар хавсарч хүргэн авчирмуй.

Нэгэн зүйл

³⁶ Бат-Оршил хэмээх утгатай Түвэд үг. Бурханы шашны томоохон хутагт хувилгаад урт наslaхын срөөл тавьж бэлэг сэлт өргөх ёслол.

³⁷ Хоёр гэсэн үг

³⁸ Манжийн төрөөс Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдуудыг хэлж буй.

³⁹ Манжийн хааныг хэлж байна.

⁴⁰ Манжийн хаанд Жавзандамба хутагт нар нэг цагаан тэмээ, найман цагаан мориор “Есөн цагааны алба” барьж байсан бөгөөд үүнийг “Цагийн алба” хэмээн нэрлэдэг ба мөн Манжийн хааны амгаланг эрж Аюуш бурхан, морь дөрвийг, Есөн цагааны найман цагаан мориноос тусад нь барьдаг байжээ.

⁴¹ Манжийн хаанд Жавзандамба хутагт “Есөн цагаан” барих ба хааны амгаланг эрж бурхан, морьд барихад Хамба номун хан, Эрдэнэ шанзудба нар дагалдан тус бүр хоёр морь барьдаг байжээ. (МУУТА. М 85. Д-2, 3-т хадгалагдаж буй баримтуудаас лавлан үзнэ үү)

⁴² Хаалгач бол Жавзандамба хутагтын шавийн захиргаа, Хүрээний Цогчин зэрэг олон газрын элдэв албан зарлаганд зарагдах ба хоног суудлын албан хүлээсэн тушаал юм.

⁴³ Хятад хүмүүс

Төр гэрэлтийн долоодугаар онд⁴⁴ Дээрхийн өмнөөс Эзний шинийн амгаланг⁴⁵ айлтгахаар одох донир⁴⁶ нар өөрийн хүчээр явж тэсэхгүй хэмээн гомдон мэдүүлсэн хэрт яамны нэгэн зайсан лам тушаасныг дагаж дуртайяа өөрийн хүчээр очиж Дээдийн амгаланг айлтгаж иржүхүй.

Нэгэн зүйл

Шавийн ам өрхийг байцаахад⁴⁷ эхлэхээр яамнаас зайсан лам долоо, бичээч хоёр, хиа ес, их сүргийн мал⁴⁸ байцаахад яамнаас зайсан лам гурав, бичээч нэг, хиа дөрөв, эдэнд сул бичээч хэд хэдийг гаргаж явуулмуй. Эдгээр зайсан бичээч хиа цөмийг ноёнтоноос⁴⁹ нэр зааж тушааж мордуулмуй. Байцааж буусан хойно данс үйлдэхэд зайсан лам нэгээр даалгажүхүй.

Нэгэн зүйл

Дотоод, гадаад аймаг, шавь, хошуу харилцан холбогдсон хулгай худлын зэрэг хүнд заргын хэрэгт газар болзон ацаг (ацау?) нийлэх шүүх хэрэгт зайсан лам, хаалгач, бичээч нарыг гаргаж явуулмуй.

Нэгэн зүйл

Дөрвөн цагт яам газрын гурван зуун тавин илүү анги хэрэг ба олон газраас ирсэн, бас олон газар явуулах албаны бичгийн хэргийг цаг бүр гурваад зайсан лам нар нижгээд хар зайсан нижгээд бичээчид тулгаж эд цөм аливаа зарлан дуудах хошуу шавь нийлсэн хэргийн гуу бичиг салгах, эх зохиох, өчиг авах байцаах зэргийг гүйцэтгэмүй. Хэрвээ түүний дотроос осолдох цалгайдах дарагдуулах зүйл буй аваас тухайн нэр бичигдэж жасаа суусан зайсан, түшмэд даруй ял торгож цээрлэл үзүүлэн шийтгэмүй.

Нэгэн зүйл

Олон газраас нэгэн жилийн эцэст мянга илүү бичиг ирэх явуулах нь үүний ирсэн бичгүүдийг тамгын бичээчээс ноёнтоноо айлтгаж гарсан хойно

⁴⁴ Энэ нь нийтийн тооллын 1827 он болно.

⁴⁵ Манжийн хаанд Жавзандамба хутагтын өмнөөс шинэ жилийн мэнд айлтгах

⁴⁶ Сүм хийдийн бичээчдийн дарга гэсэн Түвэд үг. (Монгол судлалын нэвтэрхий толь /Шашин суртахуун. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо.. 2007. т. 588). Сүм хийдийн томоохон мяндагтаны бараа бологч.

⁴⁷ Жавзандамба хутагтын шавь нарын өрх ам, малыг гурван жилд нэг удаа байцаадаг байжээ. (Зарлигаар тогтоосон Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйлийн бичиг. Жардугаар дэвтэр. МУҮНС гар бичмэл хөмрөг.)

⁴⁸ Жавзандамба хутагтын мал сүргийг хэлж байгаа ажээ.

⁴⁹ Эрдэнэ шанзудбыг мөн ноёнтон хэмээдэг.

засаг, да лам нарт хар түшмэдийн газраас айлтгамуй. Явуулах бичгүүдийг тамгын бичээчнээс эх зохиож шийтгэн явуулмуй.

Нэгэн зүйл

Хэзээ тамга нээсэн цагаас эхлэн хэн хүн өдрийн дүйцэнг ба, гэрийн хэргийн хэргийг хүлээхийг бодохгүй яаманд засаг да лам нар эхлэн гэбхүй⁵⁰, донир зайсан лам нар, хар зайсан, хөлөгч⁵¹, тайж⁵², бичээчин хүртэл өдөр бүр буюу, эсвээс нэг хоёр өдрийн төдий алгасаж хэргийн олон цөөнийг үзэж цуглан хурж хиа нар хуягуудыг авч аймаг хошуу шавийн хүний амин, хулгай худал элдэв зарга зальхайн хэргийг тогтоон шийтгэж төлөвлөөд хар түшмэдийн газраас Эрдэнэ шанзудба ноёнтонд лавлан айлтгаж тогтоосон хойно сая ял хураах, анзлах, ташуурдах зүйлийг гүйцэтгэн, өчиг авч гу салгаж шийтгэн дансанд агуулж дуусгамуй. Эдгээр хэргүүдэд ер их бага хүнд хөнгөнийг бодохгүй цөм Эрдэнэ шанзудба ноён, засаг, да лам нараас тэргүүлэн зайсан түшмэд тайжид хүртэл шийтгэсэн хүн нарын нэрийг цөм уг хэрэг лүгээ холбож бичээд хойч өдөр байцаахад бэлтгэмүй.

Нэгэн зүйл

Яам үүдний зэрэг газрын жинхэнэ албаны хэрэг ба, бичиг зүйлийг засаг, да лам нар биеэр зөвлөлдөх буюу эсвээс зайсан түшмэд бичээчний газраас Эрдэнэ шанзудба ноёнтонгоо бараалхаж айлтгах, хэрд ер боогдуулж саатуулах ба, энгийн зэрэг бараалхагчдыг давхарлуулах зүйлгүй цөм хэрэг айлтгаж дуусгахыг хүлээлгэмүй.

Нэгэн зүйл

Аливаа ял торгож авсан юм зүйлийн дотроос шавь хошуу хольцолдон Их Журганаас шийтгэж хураасан зүйлээс орон үгүй ялтаны хүнсэнд хэрэглүүлж, бусдыг албанд зүтгэсэн түшмэл ардад хөхиүлэн шагнасан явдлыг жил бүр жилийн эцэст амбаст⁵³ мэдүүлээд уламжлан Журганд мэдүүлмүй. Шавь

⁵⁰ Буяныг захирагч буюу хуврагийн захирагч гэсэн утгатай Түвэд үг. Сүм хийдийн дэг жаяг, сахил санваар, сахилга бат зэрэг хэрэг явдлыг хамааран шийдвэрлэх эрхтэй албан тушаал юм. (Монгол судлалын нэвтэрхий толь /Шашин суртахуун. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо., 2007. т. 355)

⁵¹ Жавзандамба хутагтын шавийн захиргаанд ээлжлэн сууж хэрэг шийтгэх үйл ажиллагаанд оролцдог тушаал байсан ажээ. Хөлөгчийн тухай мэдээ 1796 оны үеийн архивын баримтад дурьдагддаг. (МУҮТА. М-85. Д-3. хн-61. нугалбар-4)

⁵² Жавзандамба хутагтын шавийн захиргаанд ээлжлэн сууж хэрэг шийтгэх үйл ажиллагаанд оролцдог тайж хэмээх тушаал байв.

⁵³ Манжийн төрөөс Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайдуудыг хэлж буй.

дангаар шийтгэж торгосон юм зүйлийн их төлөвийг тамгын газар хурааж бага сагыг түшмэдэд түгээмүй.

Тамгын газар хураасан зүйлийг Эрдэнэ шанзудба ноёнтонноос мэдэж өгөх ядуу гуйлагчдад өглөг ба, ялтанд зүүх гинж тушааны үнэ, бас албанд зүтгэсэн ардад хөхиүлэн шагнах зэрэгт бэлтгэмүй.

Нэгэн зүйл

Аливаа шавь, хошуу хольцолдох буюу эсвээс шавь дангаар гаргасан хэргийг анхан яаманд заалдан мэдүүлж ирмэгц хар зайсан түшмэдийн газраас хянамжлан авч урьд Эрдэнэ шанзудба ноёнтон ба, эсвээс тамга хамаарсан да ламтанаа айлтгаж, хэрвээ засаг хошуунд бичиг явуулах эсвээс тамгын бичээчинд тушааж өчиг авч явуулмуй. Харьат хэрэгтэн яамны газраа шийтгэн дуусгахыг нь элч хиа гаргаж хэрэгтэн ардыг дуудан авчирч нийлүүлэн шүүж шийтгэмүй.

Нэгэн зүйл

Гянданд хорьсон ялт хулгай нар цөм сар бүрийн шинийн нэгнээс арван таван хүртэл ээлжээр нэгэн зайсан лам, арван зургаагаас гучин хүртэл нэгэн хар түшмэл хэлэлцэн хүлээн авч гянданы хоёр дарга ба олон хуягуудын хамт байцаан шүүмүй. Үүнд мөн хулгайг осолдон алдах ба хэрэхэд хүргэвээс даагчдыг цөмийг ялалмуй. Эдгээр ялтан сахьсан зайсан түшмэдэд ордоны сойвонгоос утлага адис залж хүртээмүй.

Нэгэн зүйл

Аливаа хүнд хөнгөн ялт ард, сая ноцогдож үүний дотор хурдан тодорхойлон шүүж тусгаар ялтыг яаравчлан бариулах ба эсвээс уг хэрэг нэн хүндгүй бөгөөс чирэгдлийг аривлаж (arabalaju?) тавтувыг бодож жинхэнэ цуглаа (ṣuḷay-a?) хүлээсэхгүй. Зайсан түшмэдийн газраас бага сага эрүү тулгаж тодорхойлон, эсхүл ам төдий байцаан шүүгээд айлтгаж дуусгамуй.

Нэгэн зүйл

Майдар бурхан эргэх ба, цам бүжиглэх, найр наадам бэлэглэх зэрэгт бүхүй ноёд, блам нар ихэс цай хуримыг онуулан хувааж бариулах ба, Дээрхийн гэгээнтний залрахын хөтөл хөсгөнд явуулах бас шавийн ноёд блам нарыг энд тэнд морилоход дагаж явах, бас элдэв алба зарлаганд явуулах их бага хиа нарыг цөм яамны хар түшмэдийн газраас нэр зааж тушаан гаргамуй. Бас яамнаас албанд хаалгач лам зарж явуулах болвоос их төлөв донир нарт

тушааж гаргуулмуй. Бас хааяа албанд ноён⁵⁴, да лам ба яамнаас нэр зааж явуулах нь мөн буй.

Нэгэн зүйл

Амбасын өртөө⁵⁵ ба аливаа хэрэглэл зүйлийг хоёр аймаг⁵⁶, шавь гурван газраа онуулан тэгшлэн хуваах хэрэг болвоос аймгийн түшмэдтэй тамгын газрын бичээчнээс хэлэлцэн тэгшлэн хуваамуй. Шавиас бэлтгэх өртөө тутам хаалгач лам нижгээд, мөн бүгдийг ерөнхийлөх зайсан лам нэгийг мордуулмуй.

Нэгэн зүйл

Дээрхийн гэгээнтэний газраас дөрвөн аймгийн ноёдын шинэ жилийн мэнд мэдээр одох хаалгачны Хүрээнээс давших улааг яамнаас хиа нижгээдийг гаргаж улаа бариулан олгомуй. Бусад хэрэгт зарагдах хаалгач цөм өөрөө улаа барьж хэрэгслэмүй. Бас ч эрхэм яаралтай албаны хэрэг гарваас мөн яамны улааг элбэж бариулан өгөх мөн буй.

Нэгэн зүйл

Яамны шүтээний тогтмол зул тахил ба сар бүрийн шинийн найман, арван тавны өдөр сахиус, манла мандалшиба (mangdalasiba?), түй тахил зэргийн хурлын хэрэгсэлд их сангаас цагаан цав, бас сар бүрийн дөрвөн зуун гучин цай, тамгаас наян найман цай гаргаж хэрэглэмүй. Бас мягмар гараг тохиолдох өдөр тутам яамны сахиусанд их сангаас цагаан будаа алд, архи авч сэржим гаргахаас гадна, зуны думдад сарын шинийн найманд сахиусанд чонхур өргөхөд сахиусыг зайсан лам нарын ах зайсан дэлгэмүй. Шан (šan?) хэв (kkeb?) сүсхү (süskü?) үгүй. Сулга гүрмийн чобумба⁵⁷ ээлжээр нэг явмуй. Их сангаас⁵⁸ чонхурын идээ, хөл мах, нэг зуун шар цай, хүж хөвөн шар тос жимс, самбай, амттан авмуй. Үүнд гүрмийн лам умзад нэг нэг, сул лам хоёр, бүгд дөрвөн хүнийг цогчин гэбхүйн газраас тушааж гаргамуй. Бас өдөр бүр яамны зайсан бичээчин нар сахиусны сан уншмуй. Бас сар бүрийн шинийн нэгэнд яамны тахилд дотоод сангийн няраваас гүргүм, давс, хүж авмуй. Бас өдөр бүр

⁵⁴ Эрдэнэ шанзудбыг хэлж буй.

⁵⁵ Сайшаалт ерөөлтийн 7-р (1802) оны 8 сарын 14-нд гаргасан хааны зарлигаар Хүрээнд сууж хэрэг шийтгэгч сайд 10 жилд нэгэн удаа өөрийн биеэр хилийн харуулуудыг шалган байцаах болсон байдаг. (МУУТА. М-1. хн-611. т. 176-179)

⁵⁶ Энэ нь Халхын Түшээт хан. Сэцэн хан аймаг юм.

⁵⁷ Тайж тавиглах хэргийг эрхлэх лам

⁵⁸ Их сан нь гол төлөв отгийн ардуудаас авсан алба татвараас бий болсон бөгөөд Эрдэнэ шанзавын яам болон Хүрээний хурал дацангуудын зардлыг гаргаж нийлүүлнэ. (Ц.Сономдагва. Манжийн захиргаанд байсан үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалт (1691-1911). УБ., 1961. т.100)

өглөө үдэш хоёрын тахилыг цөм яамны их бичээчин тавьж өргөмүй. Бас яам үүдэн хоёр оронд манзач лам нэг явж ном түгээж цав манз барьмуй. Бас энэ хэр яамны хоногт нэг бичээч, нэг хиа, сангийн хөвгүүн⁵⁹ нэгтэй их сангаас хүнс түлш хэрэглэж хономуй. Яаманд өдөр бүр сангаас арван сандулин (sandulin?) донбо цайн эдгээр. Хэрвээ хошуу түшмэл олон цуглаваас нэг донбо цай нэмэн авч хэрэглэмүй. Бас зуны цагт сүргээс дөчөөд гүү барьж суумуй. Бас сүргийн гүүний үрсэнд яам, сан хоёр газрын бичээчин ээлжээр нэг хүн очмуй. Бас гүү үнээний үрсний чонхур ба

Тамга битүүмжлэхэд⁶⁰ хийсэн хуримаас Эрдэнэ шанзудба ноён, засаг, хоёр да лам, гэхгүй, донир, зайсан түшмэл, бичээчин хиа нар хүртэл цөм гүйцэтгэмүй. Бас Эрдэнэ шанзудба ноёнтонь Бээжин жасаанаас⁶¹ морилж ирэхэд яаманд мөн шинийн ёсоор ёсломуй.

Нэгэн зүйл

Яамны хар зайсан, хөлөгч, тайж нар жасаа⁶² халалцан суух цагт хоёр сар, нэгэн сар илүү цөм адилгүй боловч тухай дор харъяат газраас өдөр тогтоож тушааснаас хэрвээ хожимдвоос хэдэн өдөр хожимдовч өдөр дараалан дөчин таваад шар цай⁶³ торгон авч урьд улирч суусан түшмэлд олгомуй.

⁵⁹ Жавзандамба хутагтын санд лам нар ихэвчлэн ажиллахаас гадна энгийн хар хүмүүс ч ажиллаж байжээ. Тийм хүмүүсийг сангийн хүү гэдэг байжээ.

⁶⁰ Манж Чин улсын үед хууль ёсоор жил бүрийн өвлийн сүүл сарын хорьдын үеэс ирэх жилийн нэгдүгээр сарын хорьдын үе хүртэлх нэг сарын хугацаанд онц чухал яаралтай биш албыг шийтгэдэггүй. Энэ хугацаанд албан бичигт тамга тэмдэг дардаггүй. Тамга дарахын оронд тамга битүүмжилсэн гэж улаан бэхээр бичдэг байжээ. Харин дээд мэдүүлэх онц яаралтай чухал албан хэрэг гарваас бичихэд бэлтгэж тамга битүүмжлэх үедээ албан бичгийн нугалбар цаас, бичгийн дутуйн цаасан дээр тамга дарж бэлтгэл болгон хадгалдаг байсан. Тамга битүүмжилсэн хугацаа гүйцмэгц тамгын түшмэд албаны хүмүүс цуглаж тогтоосон өдөр, цагт тамгаа нээж хэрэглэдэг байжээ. Тамга битүүмжлэх гэдэг бол шинэ жилийн баяр ёслолын үеийг тохиолдуулан албан хэргийг түр завсарласны тэмдэг бөгөөд тэр үеийн албаны хүмүүсийн жил тутмын ээлжийн амралтын чөлөө чанартай зүйл байсан бололтой. (Я.Цэвэл. Монголын албан бичгийн уламжлал // Олон улсын Монгол хэл бичгийн эрдэмтдийн анхдугаар их хурал. 4-р дэвтэр. ШУА-ийн хэвлэл. УБ., 1962. т. 103-105) Энэ үед шинэлэхийн ёсоор өвлийн сүүл сарын хорин наймнаас цагаан сарын шинийн хоёр, шинийн дөрвөн шинийн таван, цагаан сарын арван дөрвөнөөс арван зургаан хүртэл вангуудаас дорогш бичиг, цэргийн олон түшмэл цөм яамлах газар төрийн хувцас өмсөхөөс албаны хэрэг шийтгэх газар цөм магнаг дээл, фүүст хүрэм өмсдөг байжээ. (М-85. Д-2, хн-128, нугалбар-60)

⁶¹ Хамба номун хан, Эрдэнэ шанзудба нар нэгэн жилээр ээлжлэн Нийслэл хот (Бээжин) орж Шинэлэхийн болон Түнли номын жасаанд оролцдог байв.

⁶² Жасаа халалцан гэдэг нь ээлж солилцон сууж алба хашихыг хэлнэ.

⁶³ ХҮII-ХҮIII зууны үеийн мөнгийг орлож байсан нэгж... шахмал ногоон цайг найм хуваасны нэг буюу цаасанд боосон задгай цай, ийм арван шар цай нэг тэмээ, найман шар цай нэгтгээд үхэр, адуу, хоёр цай нэг хоньтой тэнцэж байжээ. (Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь. Ү боть. Х-Я. УБ., 2008. т. 2881)

Нэгэн зүйл

Яамны зайсан түшмэлийг аливаа албанд мордуулах хэрэг буй аваас цөм Эрдэнэ шанзудба ноёнтоны газраас нэр зааж гаргамуй. Бас жил бүр голын орнуудын жасыг⁶⁴ байцаахад зайсан лам нэг, тамгын бичээч нэг, хиа нэгийг гаргамуй.

Нэгэн зүйл

Шавийн их, бага дарга⁶⁵, хиа нарын тушаал тавихад цөм яамны түшмэдийн газраас хэлэлцэж уламжлан айлтгаж тавьмуй. Үүний дотор их даргыг амбаст мэдүүлээд уламжлан Журганд мэдүүлмуй.

Нэгэн зүйл

Тамганд⁶⁶ хураасан буй юм зүйлийг нэг зайсан ламаар захиргамуй. Аливаа ялд хураах цай, мөнгө, бараа ба, жич мал худалдах зүйл буй аваас тэр малыг хэрхэн үнээр худалдах бараа болвоос ямар зүйлийн бараа хичнээн үнээр тогтоон хураах, үүний дотор харилцан заалдсан буй аваас хичнээн ямар юм шагнах, түшмэдийн хувьд хариу хичнээн гаргаж түгээх зэргийг цөм бичээчний газраас дагасан зайсан ламтай хуучин мордож зөвшин хэлэлцээд, даруй Эрдэнэ шанзудба ноёнтоноо лавлан айлтгаж тогтоомуй.

Нэгэн зүйл

Яаманд шүүсэн хаяа бага сага заргын хэрэгт бурханы өмнө төлөг тавиулахаар шийтгэсэн аваас цогчин⁶⁷ гэххүйд⁶⁸ тушаагаад гүрмийн⁶⁹ лам

⁶⁴ Нийтийн газар, олны өмч гэсэн утгатай Түвэд үг. Сүмийн хийдийн аж ахуйг жас хэмээдэг. Хүрээний дацан сүм, хийдийн жасыг Шавийн захиргаанаас байцаан үздэг байжээ.

⁶⁵ Жавзандамба хутагтын их, бага отгийн дарга нарыг хэлж байна. 1767 оноос их отгийн дарга нарыг Галаад Монголын төрийг Засах Явдлын Яамны дансанд нэрийг тэмдэглүүлэх болжээ.

⁶⁶ Жавзандамба хутагтын шавийн захиргааг хэлж байна.

⁶⁷ Хүрээний дацан, аймгуудын шашны хэргийг ерөнхийлөн захирч, шашны дотоод гол их үйлдвэр, бүтээлүүдийг эрхлэн гүйцэтгэх бөгөөд нийт лам нар нийлж хурах газар нь цогчин дуган дахь цогчин хурал байжээ. (Д. Дагвадорж. Монголын шашин суртахууны тайлбар толь. УБ., 1995)

⁶⁸ Буяныг захирагч буюу хуврагийн захирагч гэсэн утгатай түвэд үг. Сүм хийдийн дэг жаяг, сахил санваар, сахилга бат зэрэг хэрэг явдлыг хамааран шийдвэрлэх эрхтэй албан тушаал юм. (Монгол судлалын нэвтэрхий толь /Шашин суртахуун. Өвөрмонголын ардын хэвлэлийн хороо., 2007. т. 355)

⁶⁹ Гүрэм нь засал уншлага гэсэн утгатай төвд үг. Шашин шүтлэгийн домын ёсны нэг хэлбэр. Гүрэм хэмээх нь сахиусны хүчээр аюул ослоос аврагдана хэмээн итгэж, тодорхой засал хийх үйлээр гүйцэтгэдэг шүтлэгийн ёс болно. Гүрэм нь гарз гайгаас зайлуулах, өлзий хутгыг сахиулах буян хишгийг дэлгэрүүлэх арга заслын домнолыг өөртөө агуулдагаараа хувь хүн, айл өрх, хотол олноор гүйцэтгэдэг зан үйлийн шинжтэй болжээ. Гүрэм нь нарийн дэг ёстой тахил,

нэгийг авчирч яамны шүтээний өмнө эсэргүүцлийн ардын нүдний өмнө ламаар төлөг тавиулж түүгээр шийтгэж дуусгасугай.

Нэгэн зүйл

Аливаа оргодол хулгай ба, хулгугдсан алдсан барьсан мал эд өлөг сэлтийг цөм яамны бичээчин дансанд тэмдэглэмүй.

Нэгэн зүйл

Аль аймаг хошуунд шавийн ард хүний амин хулгай худлын хэрэг харилцан холбогдсон аваас аль чуулганы дарга нартай Эрдэнэ шанзудба нарын нэр хамт⁷⁰ Журганд мэдүүлмүй.

Нэгэн зүйл

Яаманд шүүсэн хэргийн дотор аймаг хошуу хольцолдсон хэргийг цөм Монгол цаазын бичгийн⁷¹ ёсоор шийтгэмүй. Шавь дангаар холбогдсон хэргийг Өндөр гэгээний⁷² цагт зохиосон хуучин Халх журам бичгийн⁷³ ёсоор шийтгэж дуусгамуй.

Нэгэн зүйл

Яаманд аливаа ял халдсан ардыг шүүхэд шаахай банз, сураар гарыг хүлэх, тахинаг шилбэнд мод давшуурлаж сөхөргөх, хэдэн өдөр шөнө унд хоол нойр авахуулахгүй шүүмүй. Бас ял халдсан эмсийг хурууны савслага хулсаар

өргөл, балин шалсайтай, мөргүүлэх ариутгах итгүүлэх арга засалтай байдгаараа онцлог болно. (Д.Дагвадорж. Монголын шашин суртахууны тайлбар толь. УБ., 1995. т. 32)

⁷⁰Халхын дорвон аймгийн засаг хошуу. Жавзандамба хутагтын шавийн харьяат нар харилцан холбогдож хулгай, хүн амины зэрэг хэрэг үйлдэхэд шавийн захиргаа, хошууны тамгын газраас түшмэд томилж шийтгэдэг байсан бөгөөд ямар ял шийтгэл оноосныг тухайн хошууны харьяалагдах чуулганы дарга, Эрдэнэ шанзудба нар нэр хамт бичиж Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яаманд илгээж хянуулдаг байжээ. 1822 оноос чуулганы дарга, Эрдэнэ шанзудба нар нэр хамт мэдүүлэх болсон байна. Үүнээс өмнө зөвхөн чуулган даргын нэрийг бичиж мэдүүлдэг байсан ажээ. (Төр гэрэлтийн онд тогтоосон чухал хэргийг хуулсан дэвтэр. МҮҮНС гар бичмэл хөмрөг)

⁷¹Монгол цаазын бичгийг анх 1643 онд Өвөрмонголыг Манжийн эрхшээлд орсны дараа баталж мөрдүүлэн, дараа нь Энх-Амгалан хааны үед буюу 1667 онд 150 гаруй зүйлтэйгээр батлан гаргажээ. Үүний дараа Тэнгэрийн тэтгэсэн хааны үед буюу 1764-1794 онд нэмэлт өөрчлөлт оруулан, бүтцийг өөрчлөн сайжруулж 12 дэвтэр, 205 зүйлтэйгээр 1795 онд хэвлэн тархаасан байна. (Б.Баярсайхан. "Монгол цаазын бичиг"-т хийсэн эрх зүйн судалгаа. УБ., 2005. т. 8) Манжийн эрхшээлийн үеийн Монголын нийгмийн олон талт харилцааг зохицуулж байсан цааз юм.

⁷²Халхын анхдугаар дүрийн Жавзандамба хутагт. Түшээт хан Гомбодоржийн хүү Занабазар (1635-1723)

⁷³ХҮИИ зууны үеийн Монголын хууль цааз. "Халх журам"-ыг эрдэмтэн С.Жалан-Аажав, Б.Баярсайхан нар тусгайлан судалжээ.

эрүү тулгаж шүүмүй. Эцэст хуульд нийлүүлэн дөнгө⁷⁴ ба, модон хадаас ташуураар ташуурдан дуусгамуй. Бас яаманд жинхэнэ зайсан түшмэд зэрэгт хүрэхгүй бага тушаалын хүн ер эрүү хорын зэрэг хийж хэрэг үл шүүмүй.

Нэгэн зүйл

Хүрээний цогчин гэгхүй нарт захирагдсан лам банди нар бага сага хэрэг хааяа гарч мэдүүлбээс хөнгөн хэргийг мөн гэгхүйд тушаан өгч шийтгүүлмүй. Бас хорин долоон аймгийн⁷⁵ гэгхүйгээс сар бүрийн шинийн нэгэнд мэдээ авч дансанд тэмдэглэмүй.

Нэгэн зүйл

Дээрхийн гэгээнтнээс олонд мөргөл хайрлахад зайсан түшмэд бараа болон явмуй. Бас өдөр бүр Эрдэнэ шанзудба ноёнтонд зайсан лам нэг, Хамба номун хан бламтанд зайсан лам нэг, суухаас гадна, мөн хол ойр газраа мориловч нэг нэг зайсан бараа болмуй. Бас Хан уулын шадарын лам дагахад зайсан лам нэг, амбасыг харуул өртөө эргэхэд зайсан лам нэг, амбасын яаманд хэрэг шүүхэд зайсан лам нэг, Маймаа заргачийн яаманд⁷⁶ хэрэг шүүхэд зайсан лам нэг, жич хүн амины хэргийг хээрийн яаманд шүүхэд зайсан лам нэг, хар түшмэл нэг, мөн яамны бичээч нэг, эд долоо хоног өнгөртөл ордонд үл бараалахмуй. Шинэд⁷⁷ амбасын цагаалга хүргэхэд зайсан лам хоёр, их бага цам бүжиглэх ба цагаан сарын шинийн нэгний цэдэрт⁷⁸ амбасын мэдээ барихад зайсан лам нижгээд, бас шинийн хуримын идээ ба, дөрвөн аймгийн шавийн даншогийн идээ даахад зайсан лам хоёр хоёр, бас өглөгийн эздийн даншогийн идээ даахад зайсан лам нэг, бас Эрдэнэ шанзудба ноёнтоньг хол газар морилсон хойно тамганд бараа болон өргөөний хэрэг ерөнхийлөн зайсан лам нэг суумуй.

⁷⁴ Манж болон Богд хаант Монгол Улсын үед хэрэглэж байсан шийтгэл. Хэрэгтний хөл, хузүүнд углах дундаа нүх бүхий дөрвөлжин мод.

⁷⁵ Хүрээний хорин долоон аймгийг нэрлэж буй хэрэг.

⁷⁶ 1720 онд Хүрээнд Хятад худалдаачдын хэргийг дагнан эрхэлсэн Журганы Зангийн газрыг байгуулжээ. (Монгол Улсын түүх. Дөтгөөр боть. УБ., 2004. т. 224) Энэхүү Журганы Зангийн газрыг Маймаа заргачийн яам хэмээсэн бололтой.

⁷⁷ Цагаан сарыг хэлж байна.

⁷⁸ Цэдэр нь өгүүлэхүйн одон хийн махбодтой. Насны даллага дуудуулах, хувцас эсгэх, эм найруулах, хөрөнгө тавих, хариулга балин гаргахад сайн. Бурханыг тайх, ихэтгэх, замд гарах, үхэгсэдийн үйл, нүүдэл суудал хийхийг тэвч. (Буддын шашин, соёлын тайлбар толь. II дэвтэр. УБ., 2000. т. 476)

Нэгэн зүйл

Яаманд сургуулийн сул бичээч лам өдөр бүр гурваад сууж бичгийн албан тусламуй.

Нэгэн зүйл

Ял халдсан ардыг өдөр шөнө үргэлж хагасааж шүүх болвоос зайсан түшмэл нэг, хиа хоёр, хуяг нартай хамт унд ба хүнс зүйлийг цөм хэрэг халдсан газраас хэрэглэмүй.

Нэгэн зүйл

Аливаа шавийн ард зарганд хүрч өмч хувийг тусгаарлах хэрэг болвоос яамнаас яамны бичээч нэг, үүдний хаалгач нэг, хиа нэгийг гаргаж хуваалгамуй.

Нэгэн зүйл

Энэ тухайд яамны албан хаах лам зайсан арван дөрөв, хар зайсан долоо, хөлөгч ес, тайж найм, бичээч гурав, сул бичээч гурав, зүтгэлийн хиа хорин нэг, суудлын бага хиа нэг зуун жаран нэг, гянданы дарга хоёр, хуяг нэг зуу болой.

Нэгэн зүйл

Үүнээс гадна яамны хамаг хэргийн чухал болох Их Журган ба, Улиастай жанжин хэбэй амбас, Хүрээний амбас, Дотоод, Гадаад чуулганы дарга, засаг хошуу, шавийн газраа хольцолдон шийтгэж баригдаагүй хүн амин, хулгай худал зарга заальхайн зэрэг хэргийн бичгийг ижилдүүлж бүсэлсэн гурван зуун тавь илүү анги захиатай хэрэг буй боловч энэ болвоос жил сар өдөр тутам тасралгүй халж нэмсээр хассаар явах нь ер нэгэн цагт тогтох зүйлгүй учирт тогтмол болгон эс өргөжээ.

Нэгэн зүйл

Халхын дөрвөн аймгаар Дээрхийн гэгээнтнээ даншог өргөж наадам бэлэглэх тухайд Халхын хан, ван, бэйл, бэйс, гүн засгийн ноёд түшмэд бүгдээр яамны өргөөнд чуулган чуулж их хурим найр хийж бэлэглэхэд ихэс багасын олбог дэвсгэр ба, идээг донир хаалгач бэлтгэмүй. Ширээ цай ба цолма таташ түшмэл хиа нар явмуй. Айраг архи ба аяга шаазанг сангийн нярав⁷⁹, түлхүүрчин⁸⁰ бэлтгэмүй. Аяга барихад хаалгач явмуй. Бөх засахад тус бүр

⁷⁹ Жавзандамба хутагтын сангийн эд хариуцах тушаал

⁸⁰ Жавзандамба хутагтын сангийн цоож түлхүүрийг баригчийг хэлж буй бололтой.

засуул хиа нижгээд, мөн хайчийн албаны хиа дөрвөөд явмуй. Зодог даахуйд их бага дарга нар явмуй.

Нэгэн зүйл

Баруун их өргөөг шинэтгэн барьж засах зэрэг тухайд өргөгч (örgögci?) лам нараас яаманд мэдүүлэн ирмэгц, яамнаас хар түшмэл хөлөгч тайж нар хиа нарыг авч очиж засалцмуй. Бас яамны өргөө ба, ноёнтоны яамлах баруун өргөөг шинэтгэх буулгах засахад сангийн түлхүүрч дарга, яамны бичээчний хамт харгалзан явж засмуй.

Нэгэн зүйл

Яамны лам хар зайсан, их дарга, хөлөгч тайж тамга яамны бичээч, бие бага дарга, шүүлэнгэ⁸¹, дэмч⁸², ажиг⁸³, мэдээчид хүртэл цөм Эрдэнэ шанзудба, засаг, да лам нарыг дагалдаж харьяат.

Нэгэн зүйл

Хуулинд Нийслэл хотод⁸⁴ албаар орсон зайсан ламд өдөр бүр таван цэнгийн хөлс буулгамуй. Их Журганаас зайсанг хошууны захирагчид адилтган шийтгэмүй.

Нэгэн зүйл

Яамны зайсан тушаал, түүний дараа их дарга, түүний дараа хөлөгч, түүний дараа тайж, түүний дараа тамгын бичээч, зүтгэлийн хиа түүний дараа яамны бичээч, бага дарга, хиа түүний дараа шүүлэнгэ, түүний дараа дэмч түүний дараа ажиг мэдээч болмуй.

Нэгэн зүйл

Зарлигийг дагаж нэгэн да ламтан, заргачийн хамт өртөөгөөр одож Ивэн, Бургалтай зэрэг газрын тариа тарих иргэд монголчуудыг байцаамуй. Үүнд зайсан лам нэг очмуй. Хэрвээ да лам нарын дотроос тусгаар албан тохиолдож эс морилвоос амбасд амаар лавлан мэдүүлээд нэгэн зайсанг орлон илгээмүй.

⁸¹ Алба, гувчуур хураагч гэсэн утгатай үг. Жавзандамба хутагтын отгийн даргад туслах тушаал.

⁸² Шүүлэнгийн орлогч (Ц.Сономдагва. Манжийн захиргаанд байсан үеийн Ар Монголын засаг захиргааны зохион байгуулалт (1691-1911). УБ., 1961. т. 110)

⁸³ Жижиг гэсэн утгатай манж үг. Отгийн доторх элдэв мэдээг хүргэх, түгээх зарлага

⁸⁴ Бээжинг хэлж буй.

Жил бүр хавар намрын цагт зарлигаар Хэнтий, Хан уулыг⁸⁵ тахихад нэгэн да лам одож амбасыг дагалдаж таймуй.

Нэгэн зүйл

Эзний жар, далан сүүдрийн баярын⁸⁶ амгаланд Дээрхийн өмнөөс да лам нэг мордохоос гадна бас амбас биеэр морилж ялт ардыг өчиг хувай (quvai-a?) явахад одох зайсан лам нэгийг суурийн зайсан лам нар зөвлөлдөн нэр зааж уламжлан ноёнтонгоо айлтгаж тогтоолгохоос гадна одох зайсан ламыг дагалдах хиа нэгийг хар түшмэд томилон гаргаж басхүү хар түшмэлээс нэгэнтэйгүүр хэрэгтэн ардыг түүгээр хуягтай илгээн гүйцэтгэж бэлтгэн хуруулах явдлыг ерөнхий дарга нарт тушаамуй. Басхүү одох зайсан лам нэгт дагалдан одох хиа даамалуудын газар мэдэгдэж морь бариулан гүйцэтгэн дуусгамуй.

Аливаа тушаалын хүн албаны чөлөө аваад уг тогтоосон хугацааны гадна нэгэн өдрөөс дээш таван өдөрт гүйцвээс гурван мал, таван өдрөөс дээш арван өдөрт гүйцвээс таван мал, арван өдрөөс дээш хорихн өдөрт гүйцвээс нэг есөн мал, хорин өдрөөс дээш гучин өдөрт гүйцвээс хоёр есөн мал, гучин өдрөөс дээш дөчин өдөрт гүйцвээс гурван есөн мал торсугай. Дөчин өдрөөс дээш болвоос чангалан нарийвчлан тодорхойлж хүндэд цээрлэл үзүүлэн залхаан шийтгэсүгэй. Гагцхүү уг чөлөө олгосон тэмдэг бичгийг албаны газраа авчирч тушаасан өдрөөс баримтлан хэлэлцмүй.

Бадаргуулт төрийн гучин гуравдугаар⁸⁷ он арван хоёр сарын шинийн дөрвөн.

Abstract: Introduction of 3 regulations of the Erdeni šanjodba's yamun of the Great šabi administration of the Jebzundamba khutuktu, preserved in the National Library of Mongolia. The texts are translated to Cyrillic Mongolian and commented.

⁸⁵ Хэнтий болон Богд хан уулыг нэрлэж байна. Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйлийн бичигт “Халхын Хэнтий уул, Хан уулыг жил бүр хавар намар хоёр цагт тайлгын хэргийг эрхэлсэн яамнаас хүж торгыг тархаан өгч тайлагтун” гэсэн буй. (Зарлигаар тогтоосон Гадаад Монголын Төрийг Засах Явдлын Яамны хууль зүйлийн бичиг. Хорин зургаадугаар дэвтэр. МУҮНС гар бичмэл хөмрөг)

⁸⁶ Манжийн хааны төрсөн өдрийн баярыг хэлж байна.

⁸⁷ Энэ нь нийтийн тооллын 1907 он болно.